

ДАРМО МААРАМБЫН “САЙН НОМЛОЛ ЦАГААН ЛЯНХУАН ЭРХИ
ХЭМЭЭХ” СУДАРТ БУЙ ЭРДЭНИЙН ЭМИЙН ТАЙЛБАР

Б.Чимээ¹, Д.Цэрэндагва², Л.Тэрбиш³, Ш.Болд⁴
^{1,2,4}АШУУИС, ³МУШУА

EXPLANATION OF PRECIOUS MEDICINES IN THE BOOK
“LEGS BSHAD BE ED’U DKAR POI ‘PHRENG BA” WRITTEN BY
DARMO MAARAMBA LUVSANCHOIDOG

Qimuge¹, Tserendagva D², Terbish L³, Bold Sh⁴
^{1,2,4}Mongolian National University of Medical Sciences
³Mongolian National Academy of Sciences

Abstract

Background: The medical works written by Darmo Maaramba Luvsanchoidog have been an important source for the theory, treatment, training and research of traditional Mongolian medicine. In recent years, number of his medical books written by dbu med (in English headless scriptures) have been found, but they are difficult to read or translate and have not been studied at all in Mongolia. Therefore, the study has been carried out to facilitate the use of handwriting medical scriptures by Darmo Maaramba Luvsanchoidog for research, teaching, and to explain complex words in his books.

Purpose: Explain the difficult words related to precious medicines in the book called “legs bshad be ed’u dkar poi ‘phreng ba zhes bya ba bzhugs so” written by Darmo Maaramba Luvsanchoidog.

Research methods: Methods of textual analysis for ancient books and analysis and synthesis were used in the study.

Conclusion: In the book “legs bshad be ed’u dkar poi ‘phreng ba zhes bya ba bzhugs so” written by Darmo Maaramba Luvsanchoidog clearly outlines the method of analyzing the sources of many precious medicines. Furthermore, the research identified that “legs bshad be ed’u dkar poi ‘phreng ba zhes bya ba bzhugs so” is a significant work to understand precious medicines in the main scriptures of medicine and thoroughly explained their content and terminology. In particular, ring srel (in English relic), which has long been forgotten in traditional medicine, has gained practical significance as it clearly explains its classification, nature, and use.

Keywords: Darmo Maaramba, handwriting, medical scriptures, precious medicines, traditional medicine

Үндэслэл

Дармо маарамба Лувсанчойдогийн бичсэн “Увдисын үндэс”-ийн тайлбар “Алтан чимэг”, “Язгуурын үндэс” болон “Онолын үндэс”-ийн тайлбар “Алтан хадмал”, “Хойд үндэс”-ийн тайлбар “Бэрх оньсны очир зангилааг тайлагч”, “Зарлигийн эрхэст харанхуйг арилгагч зул”, ховор чухаг эмчилгээний арга, нууц увдисыг багтаасан “Анагаах ухааны битүүмжит увдис” гэх мэт зохиол бүтээлүүд нь Монгол анагаах ухааны онол, эмчилгээ, сургалт, судалгааны ач холбогдолтой сурвалж бичиг болсоор иржээ^{1,2}. Дурдан буй эдгээр зохиолуудаас гадна ойрын хэдэн жилд *དབྱེ་མེད* үмэ буюу толгойгүй үсгээр өөрөөр хэлбэл бичмэл төвөдөөр бичсэн хэд хэдэн судар олдсон ч унших, орчуулах боломж муутай, огт судлагдаагүй байсаар байна³. Иймд бид Дармо маарамба Лувсанчойдогийн анагаах ухааны бичмэл судруудыг судалгаа, сургалтад ашиглах боломжийг бүрдүүлэх, ойлгоход хүнд үгийг тайлбарлахаар энэхүү сэдвийг сонгон авлаа.

Зорилго

Дармо маарамба Лувсанчойдогийн «Сайн номлол цагаан лянхуан эрхи хэмээх оршвой» гар бичмэл сударт буй эрдэнийн эмтэй холбоотой хүнд, бэрх үгийг тайлбарлах.

Судалгааны арга

1. Эх бичгийн судлалын арга

Эх бичгийн судалгааны аргыг хэрэглэн эх бичиг судлалын өнөөгийн төвшинд аль болох ойртуулахыг чармайн Дармо маарамба Лувсанчойдогийн гар бичмэл бүтээлийн тойм, уг эх, нэр, газар орон, гол онцлог, агуулга, эх хэрэглэгдэхүүн, галиг, тайлбар, харьцуулга, хөрвүүлэг зэргийг нэгэн дор хамтатган судлав.

2. Анализ, синтезийн арга

Энэ аргыг ашиглан судалж буй тухайн судар номыг бүхэлд нь задлан шинжлэв. Мөн задлан шинжилсэн материалдаа боловсруулалт, олон талын шинжилгээ, тайлбар, үнэлэлт дүгнэлт хийж, синтезийн үр дүнд бий болсон шинэлэг тал, онцлог, ач холбогдлыг тайлбарлан тодорхойлов.

Үр дүн

Бид Дармо маарамбын *ལེགས་བཤད་བེལ་དཀར་པོའི་འབྲེང་བ་ཞེས་བྱ་བ་བརྒྱུགས་སྒྲིག་* «Сайн номлол цагаан лянхуан эрхи хэмээх оршвой» толгойгүй хорхой шар үсгээр бичсэн гар бичмэл судрын эх бичгийн судалгааг эх бичиг судлалын өнөөгийн төвшинд аль болох ойртуулахыг чармайн тус судрын дотор байгаа эрдэнийн зүйлийн онцлог, галиг, тайлбар, харьцуулга, хөрвүүлэг зэргийг нэгэн дор хамтатган судлав^{4,5}.

Дагалт эрдэнийн эмийн аймаг

“Винайн эш (*འབྲེང་བ་ལྷང་*)”, “Судрын аймаг цагаан лянхуан баглаа (*མདྲོ་ལྷོ་བད་དཀར་རྒྱན་པོ་*)”, “Цагаан мөнгөн толь (*དབྱེ་མེད་མེ་མོང་*)” хийгээд Хутагтын орны баруун зүгийн Мохари (*མོ་རྩོ་རྩ*)-гийн газрын хуваарьт ариун бярманы язгуурт санасаар төрөл таалсан Самжа Бигодала Ронзода (*སམ་བྱ་བེ་ལོ་ཏ་ལ་རྩོ་ཏ*) хэмээх мэргэн ловонгийн зарлигийн үргэлжлэл хийгээд тэжээхүй ухааны гол сударт:

Эрдэнэ тэргүүтний сайн, мууг мэдсэн ч эрхэм шашдир бус, тэр үгүйд ч бус хэмээн зарлигласан мэт гурван газар (*ས་གསུམ*)-ын дээд хөтлөгч Ялгуусаны эрхт Хамгийг айлдагч Мутартаа цагаан лянхуа баригч Өршөөн нигүүлсэгч¹-д шүтэж, Энэтхэг, Нангиад, Монгол тэргүүтний адил үгүй Их эрдэнийн язгуурт эдгээрт туслах сийрүүлгийг зохиосон

¹ Ялгуусаны эрхт Хамгийг айлдагч Мутартаа цагаан лянхуа баригч Өршөөн нигүүлсэгч нь Тавдугаар Далай ламын алдар

нь тэр ч эрдэнэ бүхний эрхэм нь түүнчлэн ажирсныг ринсрэл² хэмээнэ.

1. Ринсрэл

Түүнд лагшны шарилын ринсрэл, лагшин унгарилын ринсрэл³ хийгээд гичийн үр мэт ринсрэл, номын лагшны ринсрэл дөрвөөс:

Анхан лагшин шарилын ринсрэл нь шарам (ᠠᠩᠬᠠᠨ) хэмээх дуунаас эвдлэн сүйтгэхүйгээс хагацсан бат бэх хатуу очир лагшны шарилыг найман хувьд хуваасны нэгэн болох мэт буй. Нэрийтгэлийн мах ясны өчүүхэн хувь төдийд ч орох нь буй бөлгөө. Лагшны шарилын найман хувийн домог нь бусдад тодорхой ба Мажэйда хаан (ᠮᠠᠵᠡᠢᠳᠠ) -ы хувьт бурхны лагшны шарил нь өнөө маргааш Төвдөд буй бөгөөд тахианы өндөг төдий хэмжээтэй хэмээн алдаршив.

Хоёрдугаарт, лагшин унгарилын ринсрэл нь тэргүүний үснэр хийгээд хумс тэргүүтэн ба гуравдугаарх нь өнөө маргаашийн ринсрэл хэмээн алдаршсан энэ бөлгөө. Их нь тахианы өндөг төдий ба дунд нь хятад бурцаг төдий өчүүхэн нь цагаан гич төдий бөгөөд алин зохистой гарсан нугууд болой. Эрт цагт бурхны ном бөхөхүй цагт түүнчлэн ажирсны ринсрэл нүгүүд эрдэнийн дүрсэнд хувирч, жич дээдийн номын номхотгохуй зохистой хэрэгт таван өнгөт нүд мэт долоо буй. Түүнийг харж, огторгуй уруу харахуйд өдөр одод харагдан, олон зүйлийн бөс давхарлан тавьсны доор тавьсан ч үнэнийг өгүүлбээс дээр нь гарах нэгэн бөлгөө. Тэр мэт эрдэнийн үнэ нь үнэлшгүй бөлгөө.

2. Биндэрьяа

Түүнчлэн цагаан хийгээд шар ба хөх бөгөөд гурван зүйл буйгаас анхан цагаан нь түүнчлэн ажирсны ринсрэлээс гарсан хэмээн “Судрын аймаг цагаан лянхуа”-гаас номлосон буй.

Мөн чанар нь усны өнгөтэй маш тунгалаг огторгуй өнгөөр урвахуй эрдэнэ хэмээсэн тэр ямагт болой.

Шар биндэрьяа нь муурын нүд мэт шар ба шимиг (ᠰᠢᠮᠢᠭ) хэмээхүй дотроо гурван утас нийтгэн хийсэн мэт харагдах бөгөөд галд түлсэн ч үлэмж их гэрэл гаргадаг болой.

Хөх биндэрьяа нь хувилан төрсөн гарди нугууд бээр далайн доторх могойн дүрсийг идсэний хүчээр өөрийн биеийг галд түлсэний зүрхэн шим биндэрьяа бөгөөд мөн чанар нь их хүмүүний гуяны төдий хэмжээтэй, найман талтай, шөнө зуун бээрийн газар гэрэл гарган, нарны халуунд найман гишүүн төгс сэрүүн ус буулган, найман бээрийн газрын эргэн тойрноо өвчин эмгэггүй болгон, мөнхүү үүнийг хүрдэн эргүүлэгч хаан олбоос их эрдэнийн дээд болох ба тэнгэрийн эрхт Хурмаст хийгээд Лусын эрхт нүгүүдийн зулайн эрдэнэ ч биндэрьяагийн мөн чанартай хэмээн номлосон. Энэ ямагт индранил тэргүүтэн лүгээ эс эндүүрэхийн ялгамж нь өчүүхэн төдий ногоон, шөнө магад үгүй гэрэл гарах нэгэн болой.

3. Бадмаараг

Бадмаараг хэмээх нь улаан өнгөтэй гурван зүйл. Ягаан, хүрэн улаан, шунхны өнгө мэт гурван зүйл буйгаас дундах хүрэн улааныг нэл (ᠨᠡᠯ) хэмээдэг. Зэргэмжээр арынх нь сайн болой. Үүнийг дэлгэрүүлэн гаргаваас гурван зүйлээс өнгө нь ангир улаан шар гэрэл гаргадаг нь бадмаараг хийгээд тохой хэртэй үүлэн улаан өнгийн гэрэл тасралтгүй гаргадаг нь задирага (ᠵᠠᠳᠢᠷᠠᠭ᠎ᠠ) хийгээд болсон анар өнгөтэй дугариг гэрэл цацруулдаг нь мұхарага (ᠮᠤᠬᠢᠷᠠᠭ᠎ᠠ) хийгээд сүүлчийнх нь элэг мэт гаргадаг, газарт тавьбаас гэрэл эс гарган, хүрэлцвээс гэрэл гаргадаг нь гүмида (ᠭᠦᠮᠢᠳᠠ) хэмээх нүгүүд болой.

² Ринсрэл (ᠷᠢᠨᠰᠢᠷᠢᠯ) нь ихэс дээдсийн шарилыг дэгдээхэд гарах эрдэнийн үрэл хэмээн алдаршив.

³ Лагшин унгарилын ринсрэл (ᠯᠠᠭᠰᠢᠨᠤᠨᠭᠠᠷᠢᠯᠢᠨᠷᠢᠨᠰᠢᠷᠢᠯ) нь бурхан буюу бодисадва, язгуурын лам нарын үс, хумс, хувцас навс тэргүүтний ринсрэл болно.

Үнэ нь сайн нь алтыг гучаар өсгөсөн мэт болой.

4. Индранил

Индранил хэмээх хөх их эрдэнийн зүйл гурав бөгөөд нила (ᠨᠢᠯᠠ), гаганила (ᠭᠠᠭᠠᠨᠢᠯᠠ), индранила (ᠢᠨᠳᠢᠷᠠᠨᠢᠯᠠ) лугаа гурав болой. Анхны нила нь цайвар хөх байдалтай, гэрэл нь гурван шар төдий хөх гэрэл түгээх чадалтай болой. Хоёрдугаар гаганила нь хар хөх байдалтай, наран хамаа буй зүгт гэрэл гаргах болой. Гуравдугаар индранила нь хөх гэрлийг эрхт хоёр үгүй дээд болох буй. Үүний дээгүүр бөсөөр бүтээхэд шүхэр мэт хөх гэрэл гарах буй. Мөнхүү энэ нь Сингала (ᠰᠢᠩᠭᠠᠯᠠ)-ын Бадма Ганга мөрөн (ᠪᠠᠳᠤᠮᠠᠭᠠᠨᠭᠠ)-өөс гарсан ч байдаг. Үнэ нь зэргэмжээр зуун алт хийгээд арван алт тэргүүтний үнэтэй хэмээн номлосон болой. Жич бас хүмүүний гар төдийг галд түлсэн ч эс доройтох амуй.

5. Маргад

Маргад (ᠮᠠᠷᠭᠠᠳ) хэмээх ногоон эрдэнэ гурван зүйл бөгөөд шо маргад (ᠰᠣᠮᠠᠷᠭᠠᠳ) хийгээд рагда маргада (ᠷᠠᠭᠳᠠᠮᠠᠷᠭᠠᠳ) хийгээд нила маргад (ᠨᠢᠯᠠᠮᠠᠷᠭᠠᠳ) хэмээх гурван зүйл гэж номлов. Судлахуйд бэрх бээр саран гэрэл индранила хийгээд бүня рага (ᠪᠦᠨᠶᠠᠷᠠᠭᠠ) улаан эрдэнэ маргад дээд эдгээр нүүгүүд нь хойдох нь их эрдэнийн шороон будаг дээд хэмээсэн бээр утгандаа их эрдэнэ хөх биндэрьяа бөгөөд врэда маргад (ᠪᠢᠨᠳᠢᠷᠠᠨᠢᠯᠠ) цайвар ногоон, гэрү (ᠭᠡᠷᠦ) буюу хөх биндэрьяа, нила маргад хөх ногоон бөгөөд их хөх биндэрьяа, маргад улаан ногоон бөгөөд хөх биндэрьяан үзэсгэлэн зохионгуй хэмээсний утга мөн болой. Тэр ч ухахуйяа хялбар өгүүлбээс биндэрьяагаас өчүүхэн хөхөмдөг нь индранил (ᠢᠨᠳᠢᠷᠠᠨᠢᠯᠠ), түүнээс өчүүхэн хар нь индранила бөлгөө. Шар хөх болбоос тонгам гэгэрү (ᠲᠣᠨᠭᠠᠮᠠᠭᠡᠷᠦ), түүгээр хөх дийлэнх нь их биндэрьяа, тунгалаг улаан нь бадмаараг, элгэн нь хув (ᠬᠤᠪᠠᠮᠠᠷᠠᠭ), тунгалаг цагаан хас чулуу

гаргэда (ᠭᠠᠷᠭᠡᠳᠠ), ногоон нь маргад, цайвар шар нь шимиг (ᠰᠢᠮᠢᠭ) хэмээн дуудагддаг болой.

6. Алмаас

Эрдэнийн эрхэм очир алмаас нь базархира (ᠪᠠᠵᠠᠷᠬᠢᠷᠠ) хэмээх хоёр зүйл очир алмаас бөгөөд газраас гардаг их очир алмааз хийгээд уснаас гардаг өчүүхэн алмаас хоёроос анхдугаар нь Додгири (ᠳᠣᠳᠭᠢᠷᠢ)-гээс гарна. Их, бага ямар мэт болохуйд хэлбэр нь арвай буюу тутарга мэт, бөглүү газрын чулуу мэт, болжморын өндөг (ᠪᠣᠯᠵᠢᠮᠣᠷᠢ)-ний хэлбэртэй ч гардаг хэмээдэг. Нөхцөл нь чулуун болор мөн хэмээн алдаршсан болой. Энэ ямагтыг нүдвээс эс эвдрэх, таславаас эс тасрах, түлбээс эс түлэгдэх, үрвээс эс үрэгдэх дөрвөн эрдэм төгс ба бусад эрдэнийн зүйл алин олон тасласанаар эс тасарвал найруулгын аймаг үүнд талбиваас харшлах буюу хэмээвээс эс харшлах бөгөөд бусад алин бээр эс эвдсэн ч өөрийн чадал эвсэвээс эвдэж чадна. Таслан, нүхлэн чадах болой. Мөн, бусыг шинжлэх нь өөр эрдэнийн хажууд чирвээс зураг гарвал дээд хийгээд гулган эс үйлдэн өчүүхэн төдий баригдвал эгэл, зураг юу ч эс гарвал олонх алмаас бус хэмээн магадлана. Үүнд залбирал талбиваас дээд талд гал бадран, доод талаас ус буух тэргүүтэн хүссэн бүхэн гарах бөлгөө. Тэр ч эрдэнийн эрхэм очир алмаас бөгөөд энэ нь далайгаас гардаг хэмээн сонсов. Хэлбэр нь бөглүү газрын чулуу мэт бөгөөд болжморын өндгийн хэлбэр ч гардаг. Үндэс нь мөн чанар нь чулуун болор мөн. Өчүүхэн төдий тунгалаг бээр холоос харахад нарны гэрэл тусах цагт сувд мэт. Их, бага нь магадлал үгүй элдэв гармуй. Тэр ямагт өнөө маргааш Дээд Монголоос гарсан үзэгддэг болой. Алмаас мөн, бусыг шинжлэх нь зөөлөн болорын талд чирвээс зураг гарвал маш сайн бөгөөд гулган эс үйлдэн өчүүхэн төдий баригдвал муу, энэ нь эрдэнэ бүхний эрхэм мөн. Үүгээр эс эвдрэх эрдэнэ алин ч үгүй.

Биедээ зүүвээс лусын хорлолуудыг арилгана хэмээн зарлигласан болой. Уснаас гарсан алмаас нь галаар эвдрэх ч чадал өмнөх бусад лугаа ялгамж үгүй болой.

7. Шүр

“Цагаан лянхуан баглаа”-наас: “Шүр нь далайн хөвөөнд гол модны мөчир гишүүн мэтээр эмбрэн унаснаас үзүүр нь наранд боловсорч улайх ба үндэс нь элсэнд хучигдсаар цагаан болно” хэмээн номлосон бөлгөө.

8. Сувд

Эрдэнэ чүнжүг (ᠭᠦᠨᠵᠢᠭᠦ᠋ᠷᠢᠭᠦ᠋)-ийн үг нь сунжран гажаад орда (ᠬᠡᠳᠠ) хэмээн гарди бөөлжсний утга мөн буй. Далайн захад лус могойн дүрсэнд оргоносныг идэж, жич бөөлжсэнд чүнжүг буюу гардийн бөөлжис хэмээсэн гэдэг. Язгуур нь тав буй хэмээн номлосон бөгөөд цагаан лугаа адил ба шар нь хув мэт ба хар ногоон нь эрдэнэ адил, цайвар шар хийгээд цайвар ногоон нь өмнө номлосон мөн болой. Үүнийг мөн бусыг шинжлэн үйлдэхэд гичийг чулуунд үрээд, түүний дээр чүнжүгийг үрэхэд улаан шар хунд мэт болбоос сайн, өчүүхэн төдий улаан нь муу мөн болой. Бүрзаганди (ᠪᠦᠷᠵᠠᠭᠠᠨᠳᠢ) хэмээх наран галт шил хэмээн алдаршсан нарны гэрэл лүгээ учирсан даруйд өөрийн гэрдээс⁴ бус эс гарах ба зандраганди (ᠵᠢᠨᠳᠠᠷᠠᠭᠠᠨᠳᠢ) хэмээх саран усан болор хэмээн алдаршсан арван тавны сарны гэрэл лүгээ учирсан даруйд өөрийн гэрлээс ус гардаг бөгөөд энэ ямагт маш ховорхон мөн бөлгөө. Жич Нангиадаас гарсан долзам (ᠳᠣᠯᠵᠠᠮ) хэмээх наран лугаа учирваас гал гаран, саран лугаа учирваас ус гарахуй ялгамжтай өнгө нь ногоон шар буй болой. Жич хуучны болрын язгуур хар ногоон эрдэнэ хэмээгч наршэл (ᠨᠠᠷᠰᠢᠯ) -ийн байдалт энэ ямагт эрдэнэ хэмээн алдаршсан болой.

⁴ Гэрэл гэсэн утгатай үг.

Сувданд таван зүйл язгуур буй бөгөөд ганза сувд (ᠭᠠᠩᠵᠠᠰᠤᠰᠤᠪᠦᠳᠦ), валү сувд (ᠪᠠᠯᠦᠰᠤᠰᠤᠪᠦᠳᠦ), рамба сувд (ᠷᠠᠮᠪᠠᠰᠤᠰᠤᠪᠦᠳᠦ), бадам сувд (ᠪᠠᠳᠠᠮᠰᠤᠰᠤᠪᠦᠳᠦ), виши сувд (ᠪᠢᠰᠢᠰᠤᠰᠤᠪᠦᠳᠦ) лугаа тав болой.

Анхдугаар нь: Их, бага нь лүнтан (ᠯᠦᠨᠲᠠᠨ) -гийн хэмжээ төдий цагаан өнгөтэй, энэ ямагт дээд их зааны тэргүүн буюу соёоноос гаран, үнэ өртөг нь алтыг арав нугалсан лугаа адил хэмээн алдаршсан болой.

Хоёрдугаарт, валу сувд хэмээх нь өчүүхэн төдий хөхөмдөг өнгөтэй Энэтхэгийн өмнө зүгийн ой шугуйд хулсны навчинд хурбуун үйлдснээс гарсан бөгөөд, үнэ өртөг нь өмнөх мэт ээ.

Гуравдугаарт, рамба сувд нь өчүүхэн төдий ногоон байдалтай Энэтхэгийн өмнө зүгийн нэгэн өчүүхэн тивд гэлаша мод (ᠭᠡᠯᠠᠰᠢᠮᠣᠳ) -ны навчинд хур буун үйлдсэнээс гарсан бөгөөд хоёул их, бага нь бурцаг төдий буй ба үүнээ үнэ өртөг нь алтны үнийг хоёр нугалсан төдий болой.

Дөрөвдүгээрт, бадам сувд нь баруун зүгийн Хор орон⁵-ы зарим нэгэн могойн тархинаас гарах бөгөөд их, бага нь анарын үрийн төдий улаан өнгөтэй, үнэ өртөг нь өмнөх лүгээ адил үзэгдэх бөлгөө.

Тавдугаарт, шиви сувд (ᠰᠢᠪᠢᠰᠤᠰᠤᠪᠦᠳᠦ) нь өчүүхэн төдий шар өнгөтэй бөгөөд их, бага нь магадлал үгүй гармуй. Үнэ өртөг нь их, багаар жишсэн харагддаг. Хясааны дотроос гардаг мөн болой. Жич бас зарим нэгэн бээр хясаатай төсөөтэй банзи (ᠪᠠᠨᠵᠢ) хэмээх амьтнаас гардаг хэмээгч нүүгүүд нь мунхарсан бөлгөө. Өмнө өгүүлснээс нэрийн зүйл тоо нугууд ч “хясаанаас гарсан (ᠬᠢᠶᠠᠰᠠᠨᠠᠭᠤᠰᠠᠨ), “хясааны хөрөнгө (ᠬᠢᠶᠠᠰᠠᠨᠠᠬᠣᠷᠦᠨᠭᠡ)” хэмээсэн хийгээд тэжээхүй ухааны гол шүн судраас ч “хясааны хүчин сувд луугаа ялгамж үгүй” хэмээн зарлигласан болой.

⁵ Хор орон (ᠬᠣᠷᠣᠨ) нь 1. Хойт Төвөд, 2. Монгол, 3. Сартуул, 4. Шарайгол, 5. Уйгар, 6. Татаар хэмээсэн олон утгайтай

Чулуунаас гарсан эрдэнэ хуучин оюу бөгөөд зургаан цагаан, зургаан улаан, арилсан оюу хэмээн гуравт таалдаг. Цагаан нь их зургаан цагаан бэсрэг (ᠰᠤᠶ᠋ᠢᠨ) хэмээгч нь адыг сахихуйн дээд мөн болой. Лигвүмиг (ᠯᠢᠭᠪᠦᠮᠢᠭ)᠖ долоо, тав, гурав, цайвар хүжийн зурагт (ᠰᠤᠶ᠋ᠢᠨᠰᠤᠬᠤᠨᠢᠨᠠᠭ) цайвар шар, алаг, хар тэргүүтэн олон буйн дээд дээдэх нүгүүдийн дээдээр адыг сахихад сайн.

Үнэт эрдэнэ лигвүмиг хэмээхийг хүсэх болбоос өнөө маргааш Хам хэмээх орноос гарсан байх бөлгөө.

9. Алт

*Алин эрдэнийн эмийн аймгийн үест
Алт насыг уртадган, өтлийг чангалж,
эрдэнийн хор арилгана
Ахиулаад мөнгө бээр шар усны өвчин
хийгээд өгөр цус хатаана” хэмээх*

тэргүүтнийг зарлигласнаас алт нь шар өнгөт эрдэнэ бөлгөө. Ялгаваас, Замвү мөрний алт (ᠠᠯᠲᠤᠨᠠᠯᠲᠤ) хийгээд энгийн алт болой. “Саран гэрэл (ᠰᠤᠷᠠᠨᠭᠡᠷᠢᠯ)”-ийн бүлэгт: “Урт наст шувуу⁷-ны сангаснаас гарсан алт ялгамжтай ба загас бээр Замвү дриша (ᠵᠠᠮᠪᠦᠳᠢᠷᠢᠰ᠎ᠠ) мод идсэний сангас алт болсныг Замвү мөрний алт хийгээд шоргоолжны үүрний алт маш их улаан хийгээд Гарлог⁸-ийн алт өчүүхэн төдий улаан хийгээд алтны мөн чанар болой” хэмээн зарлигласан билээ.

10. Мөнгө

Мөнгөнд цагаан, хөх хоёр нь хольцоогүй буй. Хүрэл нь мөнгө хүрэл лүгээ холилдсон хийгээд хаян хали (ᠬᠠᠶ᠋ᠠᠨᠬᠠᠯᠢ) лугаа холилдсон тэргүүтэн гарсан ч бодитой хоёр нь сайн болой.

Зэсэнд эр зэс, эм зэс, манин зэс, болор

чулуу (ᠴᠢᠯᠠᠭ), цэнхэр хөх (ᠴᠡᠨᠬᠡᠷᠬᠡᠬᠡ) лүгээ тав болой.

Тугалганд хар, цагаан хоёроос цагаан нь шөнө дэгдэн ууршаад, цагаан тугалга хийгээд хар нь тугалга ямагт болой. Тэр ч эрдэнийн үрлийн найрлаганд их, дунд, бага гурав буйн эрдэнийн энэ найрлагын оройн чимэг болсон тийн ялгуусан арүр нь тэнгэрийн орноос гарсан хэмээн алдаршсан бөгөөд үүний үчин их эрдмүүд өгүүлж баршгүй буй.

“Тэжээхүйн намжал арүр эс ирвээс арүрийг хоёроор барилдуулах, гурваар барилдуулах, үзүүрийг төмөр гох мэт ирүүлэхүй хийгээд найман талаар ч их болох болой. Анагаах ухааны гол судраас гарсан нугуудыг өчүүхэн төдий өгүүлэхэд зургаан амт төгс, найман амт төгс, арван долоон эрдэм төгссөн, өвчний язгуур болсон нугуудыг арилгасан, сайн үнэрт, харваас үзэсгэлэнтэй, сэтгэлд зохистой, эмийн асуулт түгсэн нүгүүдэд дөрвөн зуун дөрвөн өвчин эс гарахуй буй болой” хэмээсэн хийгээд тэр ямагтаас: “Тийн ялгуусан хулууны сүүл мэт, хий, шар, бадган хурсан өвчин нүгүүдийг дармуй. Ялангуяа өлзийт хэрэг бүхэн бүтсэн бээр сайн” хэмээн зарлигласан болой.

11. Лавай

Лавайд дөрвөн зүйл бөгөөд чинава (ᠴᠢᠨᠠᠪᠠ) хэмээсэн баруун эрчлээт бөгөөд лавайнаас лавайд, лавайд төрсөн тавыг аваад, өнгө бүхэн мэт болой. Энэ нь маш чухаг үзэгддэг болой. Валавади (ᠪᠠᠯᠠᠪᠠᠳᠢ) хэмээх тэргүүтэн зүүн эрчлээт бөгөөд огоот алдаршсан нугууд болой. Ганяшиха (ᠭᠠᠨᠶ᠋ᠠᠰᠢᠬ᠎ᠠ) хэмээх эвэрт өргөстөн бөгөөд жидүр (ᠵᠢᠳᠦᠷ) -ийн үүд мэт лавайн өргөстөн түгэн төрөх болой.

Рагдашиха (ᠷᠠᠭᠳᠠᠰᠢᠬ᠎ᠠ) хэмээх улаан лавай синдүра (ᠰᠢᠨᠳᠦᠷᠠ) -гийн өнгө мэт болой⁶.

⁶ Лигвүмиг нь тогос чулуу, чулуун ногооц, тунсаа хэмээн эмийн сударт тэмдэглэгдсэн

⁷ Урт наст шувуу (ᠰᠤᠶ᠋ᠢᠨᠰᠤᠬᠤᠨᠢᠨᠠᠭ) нь цагаан тогоруу, өл халзан тогорууны ёгт нэр

⁸ Гарлог (ᠭᠠᠷᠯᠣᠭ) 葛逻禄 Кашмыр орны Эртний Түрэгийн нэгэн угсаа, түүний хаан нь XI зууны үед Лха лам Иш Одыг хөнөөсөн билээ. Бас Зүүн хойт Төвдөд нутаглах түрэг угсаат малчин овог аймаг

Дүгнэлт

Дармо маарамба Лувсанчойдогийн «Сайн номлол цагаан лянхуан эрхи хэмээх оршвой» гар бичмэл судар нь олон эрдэнийн эмийн эх булгийг шинжлэх арга, эмийн гол судруудад байгаа эрднийн эмийг хялбар ойлгуулах, тэдгээрийн агуулга, нэр томъёог сайтар тайлбарлсан улаан хөтөлбөр болсон бүтээл болох нь судалгаагаар тогтоогдов. Ялангуяа уламжлалт анагаах ухаанд мартагдах шахаад байсан ринсрэл түүний ангилал, мөн чанар, хэрэглээг ойлгомжтой тайлбарласан нь практикийн ач холбогдолтой хэмээн үзэж байна.

Ном зүй:

1. Qimuge, Тэрбиш Л, Болд Ш. Дорнын их оточ, Дармо маарамба Лувсанчойдогийн цадиг, түүхийг судлах асуудал. Монголын Анагаах Ухаан. УБ, 2019, No1 (187) p.60-64
2. Qimuge, Bold Sh. Дармо маарамба Лувсанчойдогийн намтар, бүтээлийн тухай мөчид өгүүлэх нь 中国民族医药协会 蒙医药专业委员会成立大会暨首届学术年会：探讨“达日茂玛仁巴·罗布桑超日嘎”的自传与著作 2018.8
3. Чимэг, Л.Тэрбиш, Ш.Болд, Төвөд үсэг бичгийн хэлбэр түүний ялгаа, онцлогийг тодруулах нь. Mongolian Journal of Integrated Medicine: Цуврал 1, Дугаар 1, 2019, p.74 -77

4. Чимэг, Л.Тэрбиш, Ш.Болд, Төвөд үсэг бичгийн хэлбэр түүний ялгаа, онцлогийг тодруулах нь. Mongolian Journal of Integrated Medicine: Цуврал 1, Дугаар 1, 2019, p.74 -77
5. Qimuge, Terbish L, Bold Sh. New Theoretical and Methodological Concept in Traditional Medicine. Монголын уламжлалт анагаах ухааны олон улсын эрдэм шинжилгээний их хурал, Улаанбаатар хот, Төрийн ордон, 2019 оны 06 сарын 20, p.180
6. Дармо маарамба Лувсанчойдог. ལེགས་བཤད་
བེལ་དཀར་པོའི་འཕྲེང་བ་ཞེས་བྱ་བ་
བཞགས་ཤི། Сайн номлол цагаан лянхуан эрхи хэмээх оршвой. Толгойгүй хорхой шар үсгээр бичсэн гар бичмэл судар.

Уншин танилцаж, нийтлэх санал өгсөн:
Академич С.Цэцэгмаа